



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 136/БТНБ/2023/00001

Сайншанд сум

Хэрэг нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах,  
хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх  
шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох  
журмыг шинэчлэн батлах тухай

Дорноговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Д.Наранцэцэг даргалж, шүүгч Ц.Ариунзул нарыг оролцуулан, ерөнхий шүүгчийн туслах Ц.Тэгшдүүрэнг байлцуулан хийж шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгчийг болон шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэгт оролцох шүүгчийг томилох дарааллыг тогтоох, хэрэг хуваарилах журмыг батлах тухай асуудлуудыг хэлэлцэв.

Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.2.5, 19.7, 19.8, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.6 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1.Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг хавсралтаар баталсугай.

2.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрсийг нэгдсэн системд байршуулахыг Мэдээлэл технологийн мэргэжилтэнд даалгасугай.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн системд шүүгчдийн нэрсийг сугалааны дараалал болгох

1. Шүүгч Д.Наранцэцэг
2. Шүүгч Ц.Ариунзул гэх дарааллаар байршуулж тойрог үүсгэх.

3.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг Тамгын газарт хүргүүлж, нийтлэг журамд заасны дагуу хяналт тавьж ажиллахыг шүүхийн Тамгын газрын дарга /С.Бурмаа/-д даалгасугай.

013100003

5. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 136/ЗТ2023/00001 тоот тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцсугай.

6. Энэ тогтоол нь шүүгчдийн зөвлөгөөний дараагийн тогтоол гартал хүчин төгөлдөр мөрдөгдөхийг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Д.НАРАНЦЭЦЭГ

ШҮҮГЧ

Ц.АРИУНЗУЛ





Дорноговь аймаг дахь сум дундын  
Иргэний хэргийн анхан шатны шүүхийн  
Шүүгчдийн зөвлөгөөний 2023 оны  
12 дугаар сарын 21-ний өдрийн  
00001 дугаар тогтоолын хавсралт

Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах  
болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг  
сугалаагаар томилох нийтлэг журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхэд нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хэрэг хүлээн авах, шүүгчид хуваарилахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид "ИХШХШТХ" гэх/ болон 2021 оны 10 сарын 11-ний өдрийн нийт шүүгчийн чуулганаар баталсан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам болон энэхүү журмыг баримтална.

1.2. Шинээр ирсэн хэрэг /адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоож ирүүлсэн хэрэг/, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт /өөрт хуваарилагдсан хэргийг хянан шийдвэрлэх тухай шүүгчийн бүрэн эрхэд шууд хамаарах хүсэлтээс бусад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан өргөдөл, гомдол, хүсэлт/-ийг тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилна.

1.3. Хүлээн авахаас татгалзсан, буцаасан нэхэмжлэл, хэрэгсэхгүй болсон болон нэхэмжлэлээ татан авсны дараа нэхэмжлэгч уг нэхэмжлэлээ дахин гаргасан тохиолдолд урьд хүлээн авсан шүүгчид системээс гараар хуваарилж, энэ журамд зааснаар хүлээлгэн өгнө. Нэхэмжлэлийг дахин хуваарилахад тухайн нэхэмжлэл тойрогт орохгүй.

1.4. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр буцаасан хэргийг анх шийдвэрлэсэн шүүгч өөрөө хүлээн авч шийдвэрлэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас шүүгчийг татгалзан гаргасан хэргийг тухайн шүүгчийг оролцуулахгүйгээр тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар бусад шүүгчид хуваарилна.

*2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчилсөн/*

1.5. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74, 106 дугаар зүйлд зааснаар гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг мөн хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар хүчингүй болгосон тохиолдолд уг хэргийг тухайн шүүгчид хуваарилна. Тухайн шүүгч тус шүүхэд ажиллахгүй болсон тохиолдолд системээс тойрог дотор санамсаргүй аргаар шүүгчид хуваарилна.

1.6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 68.3-д заасан үндэслэлээр хэргийг нэгтгэхдээ нэхэмжлэлийг шүүхэд хүлээн авсан он, сар, өдөр, дугаараар эхэнд хүлээн авсан хэрэгт нэгтгэж, эхэнд хүлээн авсан хэргийг шийдвэрлэж байгаа шүүгч хамтатган шийдвэрлэнэ.

1.7. Нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн шаардлагыг тусгаарласан тохиолдолд тухайн захирамж гаргасан шүүгч өөрөө тусгаарласан хэргийг хянан шийдвэрлэнэ.

1.8. Согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэхээр Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шуурхай шийдвэрлэх онцлогийг харгалзан хуваарилахдаа нэхэмжлэл хүлээн авах боломжтой, тухайн өдөр ажиллаж байгаа албан ёсны чөлөөтэйгөөс бусад шүүгчид тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

1.9. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар гомдол гаргасан тохиолдолд уг хэргийг шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр гомдлыг шүүгчдийн зөвлөгөөний тогтоолд заасан дарааллаар бусад шүүгчид тойргийн журмаар хуваарилна.

1.10. Мөн шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд адил шатны шүүхээс бүрэлдэхүүн авах, шүүх бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд адил шатны шүүхэд гомдлыг хянуулахаар хүргүүлэх,

1.11. Адил шатны шүүхээс бүрэлдэхүүнд шүүгч оролцуулахыг хүссэн тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөн хийж сугалаагаар албан томилолтоор бусад шүүхэд ажиллах,

Харин шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай тохиолдолд /нэг шүүгч ажиллах үед/ тухайн шүүгч албан бичигт тусган томтлолтоор ажиллана.

*/2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчилсөн/*

1.12. Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

1.13. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгалах ба түүнд шүүхийн тамгын газрын дарга тогтмол хяналт тавина.

1.14. Улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг хэдэн хүнд холбогдуулснаас үл хамаарч зөвхөн 1 удаа баталгаажуулна. Харин актад нэр дурдсан хүн тус бүрээр гүйцэтгэх хуудсыг бичиж олгоно. Акт баталгаажуулсан шүүгч гүйцэтгэх хуудсыг бичнэ. Тухайн шүүгч ээлжийн амралттай, 14 хоногоос дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх болон журмын 3.2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүсвэл бусад шүүгч нарт хуваарилна. Мэдээлэл лавлагааны

мэргэжилтэн нь актыг хүлээн авахдаа Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хүчин төгөлдөр акт хүлээн авна.

## Хоёр. Бусад

2.1. Шүүгч ээлжийн амралт эдэлж эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилалтыг зогсоож, ээлжийн амралтаа эдлээд ажилд орохоос ажлын 5 хоногийн өмнө хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилах, мөн түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэргийг шүүгч өөрөө эцэслэн шийдвэрлэнэ.

2.2. Шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл бий болсон бол /хүндэтгэн үзэх шалтгаан, гэнэтийн байдал зэргийг харгалзан/ хэрхэн шийдвэрлэхийг тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.3. "Шүүгч сэлгэн ажиллуулах журам"-ын дагуу шүүгч адил шатны өөр шүүхэд сэлгэн ажиллах тохиолдолд үлдэгдэл хэргийг үлдсэн шүүгч нарт шүүхэд нэхэмжлэлийг хүлээн авсан он, сар, өдөр, дугаарын дарааллаар шүүгч нарын нэрсийн дарааллыг тухай бүр сугалаагаар тогтоож, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилж, ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулна. Шүүгч сэлгэн ажиллуулах журам"-ын дагуу ажилласан шүүгчийн томилолтын хугацаа дуусаж, буцаж ирэхэд тухайн шийдвэрлээгүй үлдсэн хэргийг буцаан шилжүүлнэ.

2.4. Шүүгч өөр шүүхэд шилжин ажиллахад түүнд хуваарилагдсан нэхэмжлэл, хэрэг, гомдол, хүсэлтийг үлдсэн шүүгч нарт шүүхэд нэхэмжлэлийг хүлээн авсан он, сар, өдөр, дугаарын дарааллаар үлдсэн шүүгч нарын нэрсийн дарааллыг сугалаагаар тогтоож, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилна.

2.5. Шүүгч шинээр нэмэгдэж ирсэн тохиолдолд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахдаа шүүгч нарын нэрсийг сугалаагаар тогтоож, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилна.

2.6. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт өөр шүүгчид хуваарилагдахад тухайн шүүгч, шүүгчийн туслахаас бүрэн, дугаарласан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, хуваарилагдсан шүүгчид гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө./Бүртгэлийг архивт хадгалуулна./

2.7. Бүрэлдэхүүнээр хэрэг, гомдол, хүсэлтийг шийдвэрлэж байгаа тохиолдолд тухайн хэрэг, гомдол, хүсэлт хуваарилагдсан шүүгч шүүх хуралдааныг даргална.

2.8. Ээлжийн амралт эдэлж байгаа шүүгч ээлжийн амралтынхаа дундуур орж ирэн өөрт хуваарилагдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэргийг шийдвэрлэх ажиллагааг явуулж болно.

2.9. Ерөнхий шүүгчид нэхэмжлэл, хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг бусад шүүгчийн нэгэн адил хуваарилна.